



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: САГ-2026/350/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг

Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: П.Чанцалдулам

Утас: 51-261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Мөнхжин

Утас: 51-261740 Цахим хаяг: mukhjind@audit.gov.mn

Аудитор: Г.Тэлмүүн

Утас: 51-261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	16
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	16
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
4. АУДИТЫН ТАЙЛАН	21
4.1 Ерөнхий зүйл.....	21
4.2 Материаллаг байдал	21
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	21
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	21
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	24
5.1 Төлбөрийн акт.....	24
5.2 Албан шаардлага.....	25
5.3 Зөвлөмж	29
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	31
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	31
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	32
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	36



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/297
танай _____-ны № _____-т

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
И.БАТХҮҮ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 813,328.3 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар гадны зочин төлөөлөгч хүлээн авах зардлын төсөв баталж, 15 хуулийн этгээдтэй хоол болон танхимын түрээсийн үйлчилгээний гэрээ байгуулан анхан шатны баримтаар нотлогдохгүй, гэрээ байгуулснаас өөр хуулийн этгээдийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг болон тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлэн нийт 280,544.6 мянган төгрөгийн гүйлгээг санхүүжүүлсэн;
- Сангийн сайдын 2011 оны "Гадаад албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" 188 дугаар тушаалаар баталсан зардалд тусгагдаагүй уулзалтын танхимын түрээсийн төлбөр болон тогтоосон нормативаас илүү хэмжээгээр зам хоног, зочид буудлын зардлыг төсөвлөж, нийт 70,153.5 мянган төгрөгийг хэтрүүлэн олгосон;

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүйгээс 44,529.2 мянган төгрөг, төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс 84,892.4 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан, яамны үндсэн чиг үүрэгтэй хамааралгүй 49,530.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг санхүүжүүлсэн;
- Төсвийг зохистой удирдаагүйгээс 89,422.2 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1, 2, 3, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.2, 6 дугаар зүйлийн 6.3.2, 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.2.2, 6 дугаар зүйлийн 6.1, 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.2.7 дахь заалтуудтай болон Сангийн сайдын 2011 оны "Гадаад албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" 188 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан журамтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн "Хөрөнгө гаргах тухай" 06 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас шилжүүлсэн 911,145.8 мянган төгрөгийн санхүүжилтээр бэлтгэсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А-1/1755 дугаар албан бичиг, 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Одон, орон, геофизикийн хүрээлэн рүү шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ" гэж заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/177 дугаар тушаалаар яамны зохион байгуулалтын бүтэц, орон тоог 9.0 хувиар бууруулан 151 болгон баталсан байна.

Бүтцийн шинэчлэлээр 9 газар, 19 хэлтэс, нийт орон тоо 166 байсныг 9 газар, 9 хэлтэс болгон удирдах 10 албан тушаалтан, гүйцэтгэх 5 албан тушаалтныг цомхотгон 151 орон тоотойгоор батлагдсан, гүйцэтгэлээр тайлант онд 151 орон тоотойгоор ажилласан байна.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,366,865,943.98	5,913,070,237.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	150,000,000.00	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	150,000,000.00	-
31210	Төгрөг	150,000,000.00	-
31211	Төрийн сангийн харилцах	150,000,000.00	-
33	АВЛАГА	348,048.49	564,354.10
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	7,487.90	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	564,354.00
33500	Бусад авлага	340,560.59	0.10
33520	Хувь хүмүүсээс авах авлага	340,560.59	0.10
34	УРЬДЧИЛГАА	4,450,000.00	134,895,715.24
34600	Урьдчилж гарсан зардал	4,450,000.00	134,895,715.24
35	БАРАА МАТЕРИАЛ	616,888,561.99	201,630,834.99
35400	Хангамжийн материал	616,888,561.99	201,630,834.99
35410	Бичиг хэргийн материал	21,558,081.00	12,688,346.00
35420	Аж ахуйн материал	212,676,174.49	188,049,482.49
35430	Сэлбэг хэрэгсэл	90,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	130,006.50	6.50
35470	Бусад хангамжийн материал	382,434,300.00	893,000.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	5,595,179,333.50	5,575,979,333.50
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+Бусад	5,595,179,333.50	5,575,979,333.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,363,630,596.45	2,320,009,044.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,363,630,596.45	2,320,009,044.73
39200	Биет хөрөнгө	2,209,064,287.44	2,282,218,488.53
39203	Авто-тээврийн хэрэгсэл	379,090,000.00	592,423,333.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	(178,288,639.16)	(259,657,038.20)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,939,055,542.78	1,843,537,081.97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(940,301,247.75)	(902,615,517.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,194,469,824.70	1,287,255,861.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	(185,380,193.13)	(279,144,232.60)
39217	Ном	419,000.00	419,000.00
39300	Биет бус хөрөнгө	154,566,309.01	37,790,556.20
39303	Бусад биет бус хөрөнгө	588,875,080.75	134,183,520.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(434,308,771.74)	(96,392,963.80)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	8,730,496,540.43	8,233,079,282.56
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	181,004.00	92,282,142.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	181,004.00	92,282,142.30
41300	Өглөг	181,004.00	92,282,142.30
41360	Бусад өглөг	181,004.00	92,282,142.30
41361	Байгууллагад төлөх өглөг	-	81,711,650.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,004.00	10,570,492.30
41364	НДШ-ийн өглөг /ТӨҮГ/	180,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,730,315,536.43	8,140,797,140.26
51	Засгийн газрын хувь оролцоо	8,730,315,536.43	8,140,797,140.26
51200	Хуримтлагдсан үр дүн	8,730,315,536.43	8,140,797,140.26
51210	Өмнөх үеийн үр дүн	8,806,460,328.40	8,755,373,981.63
51220	Тайлант үеийн үр дүн	(76,144,791.97)	(614,576,841.37)

Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	8,730,496,540.43	8,233,079,282.56
---	--	-------------------------	-------------------------

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он <i>/төгрөгөөр/</i>
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	15,562,104,766.68	13,241,585,856.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,004,133.06	13,241,585,856.21
120	Нийтлэг татварын бус орлого	9,004,133.06	312,607,136.21
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	9,004,133.06	312,607,136.21
122	Тусламжийн орлого	-	12,928,978,720.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	12,928,978,720.00
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	12,011,452,900.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	12,011,452,900.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	917,525,820.00
122133	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	911,145,820.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	6,380,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,553,100,633.62	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	12,505,593,299.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,505,593,299.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,047,507,334.62	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	68,343,750.00	-
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,979,163,584.62	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	15,506,619,580.74	12,817,088,392.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,506,619,580.74	12,817,088,392.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,591,989,546.48	10,358,190,515.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,168,877,194.58	5,532,872,857.86
210101	Үндсэн цалин	2,510,020,665.75	3,260,676,794.40
210102	Нэмэгдэл	846,487,898.83	928,339,644.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	484,089,000.00	923,846,009.11
210104	Урамшуулал	328,279,630.00	420,010,410.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	530,543,979.27	701,909,155.58
210201	Тэтгэврийн даатгалын зардал	367,411,009.54	481,708,881.10
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	42,197,134.66	56,579,406.05
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	20,554,453.92	27,622,839.02
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	20,022,200.70	27,172,850.83
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	80,359,180.45	108,825,178.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,622,700.00	82,630,800.00



Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	25,207,100.00	39,701,200.00
210302	Түлш, халаалт	14,740,300.00	24,027,200.00
210303	Цэвэр, бохир ус	6,675,300.00	18,902,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	234,060,316.52	723,039,872.96
210401	Бичиг хэрэг	86,431,342.00	91,749,985.00
210402	Тээвэр, шатахуун	29,690,250.00	35,320,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	40,919,984.39	46,156,619.96
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	77,018,740.13	102,554,386.00
210408	Бараа материал акталсны зардал	-	447,258,532.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,955,497.00	27,017,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,601,150.00	-
210604	Урсгал засвар	24,354,347.00	27,017,800.00
2107	Томилолт, зочны зардал	1,256,618,644.17	1,233,822,867.45
210701	Гадаад албан томилолт	781,535,782.01	759,651,598.45
210702	Дотоод албан томилолт	107,674,689.00	101,542,015.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	367,408,173.16	372,629,254.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,451,530,560.00	1,207,985,644.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,389,149,211.00	905,936,070.00
210803	Даатгалын үйлчилгээ	4,000,000.00	4,845,604.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	212,048.00	663,192.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	56,549,301.00	294,540,778.20
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,620,000.00	2,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,871,780,654.94	848,911,517.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,992,443,184.62	34,315,734.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	51,168,020.00	106,059,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	828,169,450.32	708,536,182.14
212	ТАТААС	748,994,586.19	2,227,981,700.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	748,994,586.19	2,227,981,700.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	748,994,586.19	2,227,981,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,165,635,448.07	230,916,177.05
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	170,980,000.00	119,737,577.05
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	119,737,577.05
213111	Төрийн сангаас харъяа төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн зардал	-	88,131,083.46
2131111	Урсгал санхүүжилтийн зардал	-	88,131,083.46
213112	Төсвийн байгууллагаас харъяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	31,606,493.59
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	25,226,493.59
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	6,380,000.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	170,980,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,622,800.00	111,178,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	84,622,800.00	111,178,600.00

Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,910,032,648.07	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,903,050,396.64	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	6,982,251.43	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	55,485,185.94	424,497,464.08
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	131,629,977.91	1,039,074,305.45
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	2,352,812.08
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	130,061,977.91	96,893,553.37
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	1,568,000.00	939,827,940.00
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(131,629,977.91)	(1,039,074,305.45)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(76,144,791.97)	(614,576,841.37)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	15,710,082,885.05	12,954,769,567.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	156,982,251.43	12,954,769,567.59
120	Нийтлэг татварын бус орлого	156,982,251.43	-
120009	Бусад орлого	156,982,251.43	-
122	Тусламжийн орлого	-	12,954,769,567.59
1221	Хандив тусламж /дотоод/	-	12,954,769,567.59
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	12,037,243,747.59
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	12,011,452,900.00
122112	Хөрөнгийн санхүүжилтийн орлого	-	25,790,847.59
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	917,525,820.00
122133	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	911,145,820.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	6,380,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,553,100,633.62	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	12,505,593,299.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,505,593,299.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,047,507,334.62	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	68,343,750.00	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,979,163,584.62	-
II		14,886,812,292.14	12,653,215,707.93
21	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,886,812,292.14	12,653,215,707.93
210	УРСГАЛ ЗАРДАЛ	11,970,626,757.88	10,194,253,476.88
2101	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,168,372,452.21	5,532,872,857.86
210101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,508,860,097.85	3,260,676,794.40

Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210102	Үндсэн цалин	845,507,888.00	928,339,644.35
210103	Нэмэгдэл	485,770,836.36	923,846,009.11
210104	Унаа хоолны хөнгөлөлт	328,233,630.00	420,010,410.00
2102	Урамшуулал	530,363,979.27	701,909,155.58
210201	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	367,231,009.54	481,708,881.10
210202	Тэтгэврийн даатгалын зардал	42,197,134.66	56,579,406.05
210203	Тэтгэмжийн даатгалын зардал	20,554,453.92	27,622,839.02
210204	ҮОМШӨ-ний даатгалын зардал	20,022,200.70	27,172,850.83
210205	Ажилгүйдлийн даатгалын зардал	80,359,180.45	108,825,178.58
2103	Эрүүл мэндийн даатгалын зардал	46,622,700.00	82,630,800.00
210301	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,207,100.00	39,701,200.00
210302	Гэрэл, цахилгаан	14,740,300.00	24,027,200.00
210303	Түлш, халаалт	6,675,300.00	18,902,400.00
2104	Цэвэр, бохир ус	187,551,732.79	202,305,567.96
210401	Хангамж, бараа материалын зардал	68,286,128.00	60,033,690.00
210402	Бичиг хэрэг	32,551,562.00	35,190,350.00
210403	Тээвэр, шатахуун	40,919,984.39	46,156,619.96
210406	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	45,794,058.40	60,924,908.00
2106	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	78,450,897.00	47,406,350.00
210601	Эд хогшил, урсгал засварын зардал	51,541,250.00	3,040,000.00
210604	Багаж, техник, хэрэгсэл	26,909,647.00	44,366,350.00
2107	Урсгал засвар	1,256,618,643.99	1,233,821,905.15
210701	Томилолт, зочны зардал	781,535,781.83	759,650,636.15
210702	Гадаад албан томилолт	107,674,689.00	101,542,015.00
210703	Дотоод албан томилолт	367,408,173.16	372,629,254.00
2108	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,508,773,348.00	1,307,577,095.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,441,542,699.00	879,308,898.00
210803	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,450,000.00	395,604.00
210804	Даатгалын үйлчилгээ	212,048.00	663,192.00
210806	Тээврийн хэрэгслийн татвар	56,948,601.00	425,209,401.15
210809	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,620,000.00	2,000,000.00
2109	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,193,873,004.62	1,085,729,745.18
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,142,704,984.62	979,670,145.18
210902	Бараа үйлчилгээний бусад зардал	51,168,020.00	106,059,600.00
212	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	750,550,086.19	2,227,981,700.00
2122	ТАТААС	750,550,086.19	2,227,981,700.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	750,550,086.19	2,227,981,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,165,635,448.07	230,980,531.05
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	170,980,000.00	120,301,931.05
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	120,301,931.05
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	120,301,931.05
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	88,131,083.46
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	25,226,493.59
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	6,380,000.00

Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2131125	Төсвийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	564,354.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	170,980,000.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	84,622,800.00	110,678,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	84,622,800.00	110,678,600.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,910,032,648.07	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,903,050,396.64	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	6,982,251.43	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	823,270,592.91	301,553,859.66
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	771,270,592.91	451,553,859.66
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	771,270,592.91	451,553,859.66
2200	Дотоод эх үүсвэрээр	771,270,592.91	451,553,859.66
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	771,270,592.91	451,553,859.66
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(771,270,592.91)	(451,553,859.66)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	52,000,000.00	(150,000,000.00)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	98,000,000.00	150,000,000.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	150,000,000.00	-
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	15,710,082,885.05	12,954,769,567.59

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	8,807,868,733.40	8,807,868,733.40
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,408,405.00)	(1,408,405.00)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	8,806,460,328.40	8,806,460,328.40
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(76,144,791.97)	(76,144,791.97)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	8,730,315,536.43	8,730,315,536.43
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	24,878,445.20	24,878,445.20
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	8,755,373,981.63	8,755,373,981.63
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(614,576,841.37)	(614,576,841.37)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	8,140,797,140.25	8,140,797,140.25

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	17,050,639,900.00	11,923,321,816.54	5,127,318,083.46	69.9
Татварын бус орлого	17,050,639,900.00	11,923,321,816.54	5,127,318,083.46	69.9
Тусламжийн орлого	17,050,639,900.00	11,923,321,816.54	5,127,318,083.46	69.9
Төсвөөс санхүүжих	17,050,639,900.00	11,923,321,816.54	5,127,318,083.46	69.9
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,050,639,900.00	11,923,321,816.54	5,127,318,083.46	69.9
УРСГАЛ ЗАРДАЛ	17,050,639,900.00	11,923,321,816.54	5,127,318,083.46	69.9
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,229,561,100.00	9,628,361,516.54	2,601,199,583.46	78.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,705,781,900.00	5,525,672,857.86	180,109,042.14	96.8
Үндсэн цалин	3,412,534,200.00	3,260,676,794.40	151,857,405.60	95.5
Нэмэгдэл	1,107,738,700.00	928,339,644.35	179,399,055.65	83.8
Унаа хоолны хөнгөлөлт	772,449,500.00	923,846,009.11	(151,396,509.11)	119.6
Урамшуулал	413,059,500.00	412,810,410.00	249,090.00	99.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	759,058,900.00	701,909,155.58	57,149,744.42	92.5
Тэтгэврийн даатгал	516,160,000.00	481,708,881.10	34,451,118.90	93.3
Тэтгэмжийн даатгал	60,724,700.00	56,579,406.05	4,145,293.95	93.2
ҮОМШӨ-ний даатгал	30,362,400.00	27,622,839.02	2,739,560.98	91.0
Ажилгүйдлийн даатгал	30,362,400.00	27,172,850.83	3,189,549.17	89.5
Эрүүл мэндийн даатгал	121,449,400.00	108,825,178.58	12,624,221.42	89.6
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,630,800.00	82,630,800.00	-	100.0
Гэрэл, цахилгаан	39,701,200.00	39,701,200.00	-	100.0
Түлш, халаалт	24,027,200.00	24,027,200.00	-	100.0
Цэвэр, бохир ус	18,902,400.00	18,902,400.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	266,371,100.00	192,805,567.96	73,565,532.04	72.4
Бичиг хэрэг	69,666,300.00	50,533,690.00	19,132,610.00	72.5
Тээвэр, шатахуун	63,604,900.00	35,190,350.00	28,414,550.00	55.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	46,786,800.00	46,156,619.96	630,180.04	98.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	86,313,100.00	60,924,908.00	25,388,192.00	70.6
Эд хогшил, урсгал засварын зардал	626,040,200.00	448,972,209.66	177,067,990.34	71.7
Багаж, техник, хэрэгсэл	576,900,200.00	404,605,859.66	172,294,340.34	70.1
Урсгал засвар	49,140,000.00	44,366,350.00	4,773,650.00	90.3
Томилолт, зочны зардал	2,642,979,800.00	1,233,821,905.15	1,409,157,894.85	46.7
Гадаад албан томилолт	1,313,621,100.00	759,650,636.15	553,970,463.85	57.8
Дотоод албан томилолт	170,588,300.00	101,542,015.00	69,046,285.00	59.5
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,158,770,400.00	372,629,254.00	786,141,146.00	32.2
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,024,409,400.00	1,357,565,095.15	666,844,304.85	67.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,408,519,100.00	929,296,898.00	479,222,202.00	66.0

Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Даатгалын үйлчилгээ	656,600.00	395,604.00	260,996.00	60.3
Тээврийн хэрэгслийн татвар	663,200.00	663,192.00	8.00	100.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,201,400.00	-	2,201,400.00	-
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	610,369,100.00	425,209,401.15	185,159,698.85	69.7
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,000,000.00	2,000,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	122,289,000.00	84,983,925.18	37,305,074.82	69.5
Бараа үйлчилгээний бусад зардал	91,800,000.00	68,524,325.18	23,275,674.82	74.7
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,489,000.00	16,459,600.00	14,029,400.00	53.9
ТАТААС	4,748,397,800.00	2,227,981,700.00	2,520,416,100.00	46.9
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,748,397,800.00	2,227,981,700.00	2,520,416,100.00	46.9
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,748,397,800.00	2,227,981,700.00	2,520,416,100.00	46.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,681,000.00	66,978,600.00	5,702,400.00	92.1
Бусад урсгал шилжүүлэг	72,681,000.00	66,978,600.00	5,702,400.00	92.1
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	72,681,000.00	66,978,600.00	5,702,400.00	92.1
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-	-	-
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-	-	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
Төсвийн байгууллага	1	1	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	139	151	12	108.63
Удирдах ажилтан	25	21	-4	84.00
Гүйцэтгэх ажилтан	107	120	13	112.15
Үйлчлэх ажилтан	7	10	3	142.86
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	139	151	12	108.63
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	130	128	-2	98.46
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	7	10	3	142.86
Улс төрийн албан хаагч (УТ)	2	13	11	650.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан
2025 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	917,525,820.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	917,525,820.00
122	Тусламжийн орлого	-	917,525,820.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	917,525,820.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	917,525,820.00
350013	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	911,145,820.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	6,380,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	917,525,820.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	917,525,820.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	911,145,820.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	911,145,820.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	911,145,820.00
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	6,380,000.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	-
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Эдийн засаг, хөгжлийн яам нь эрхэм зорилгоо “Шинжлэх ухааны нотолгоонд суурилан эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж, инновац, технологи, хувийн хэвшилд суурилсан төрөлжсөн эдийн засгийн бүтцийг хөгжүүлэх, хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн чадавхыг сайжруулж, хүртээмжтэй болгох, бизнесийн эрх чөлөөг тогтвортой хангахад оршино” гэж тодорхойлсон байна.

Яам нь үйл ажиллагааны эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлнэ: Үүнд:

- Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг улс, бүс, орон нутаг, салбар хоорондын уялдааг ханган боловсруулах, хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлтийг хийх, хүн амын өсөлтийг дэмжих, хүний хөгжлийг хангах, нэгдсэн бодлогыг тодорхойлох;
- Макро эдийн засгийн тэнцвэрт байдал, тогтвортой өсөлтийг хангах, өрсөлдөх чадварыг сайжруулах бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл, төлөвлөлт, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулах;
- Шинжлэх ухаан, технологийн судалгаа, хөгжүүлэлт, технологи, инновацын шилжилтэд суурилсан эдийн засгийн эрчимтэй хөгжлийн чиглэлээр урт, дунд хугацааны бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, эрх зүйн баримт бичиг боловсруулах, батлуулах, түүнд нийцсэн төсвийн хэрэгцээний шинжилгээ хийх, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах;
- Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа болон гадаад, дотоод худалдааны бодлогыг тодорхойлох, нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтаар хангах, холбогдох гэрээ, хэлэлцээрийг тохиролцох, байгуулах, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хэрэгжилтэд хяналт тавих;
- Хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлох, төлөвлөх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төслүүдийг хэрэгжүүлэх хувилбар, хөгжүүлэлтийг хийж, бэлэн байдлыг хангуулах, хөрөнгө оруулалт, татах, дэмжих, хамгаалах, ногоон санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх,
- Аж үйлдвэрийн төлөвлөлт, эдийн засгийн салбаруудын бүтцийн өөрчлөлт, шинэчлэлийн бодлого, төрийн зохицуулалтыг хялбарчлах, бизнесийн орчныг дэмжих бодлогыг тодорхойлох цогц арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран үе шаттай хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт тавих,
- Хөгжлийн төсөл, хөтөлбөрийн нийгэм, эдийн засагт үзүүлэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн нэгдсэн бодлого, арга хэмжээг тодорхойлох, байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, оролцоог нэмэгдүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, эдийн засгийн коридорын төслүүдийг идэвхжүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг бий болгож, санхүү, хөрөнгө оруулалт, хууль, эрх зүй болон гадаад харилцаа, хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах асуудлыг хариуцах, яамны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах;
- Үндэсний хэмжээнд хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн гаргах, сайдын эрхлэх асуудлын хүрээний үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, яамны үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Яам нь холбогдох бодлогын баримт бичиг, хууль тогтоомжид тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэх, Монгол Улсын тогтвортой хөгжил, эдийн засгийг сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, эрхэм зорилго, гол зорилтуудыг оновчтой, зөв тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхдээ судалгаа, шинжилгээнд үндэслэсэн өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон бодлого, арга хэмжээгээр сайд, үйлчлүүлэгч, хэрэглэгчдийг хангаж, тэдгээрт бүх талын дэмжлэг тусалцаа үзүүлэх явдал юм.

Үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын ерөнхий хууль тогтоомжууд, Сангийн сайдын холбогдох журам, заавруудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд яамны үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай;
- Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Сангийн сайдын баталсан холбогдох журам заавар.

Яамны удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Тайлант онд Хяналт, шинжилгээ, үнэлгээний газраас яамны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудитыг гүйцэтгээгүй байна. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Эдийн засаг, хөгжлийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/113 тоот тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан бөгөөд тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 497,417.3 мянган төгрөгөөр буюу 5.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	150,000.0	-	(150,000.0)
Авлага	348.0	564.4	216.4
Урьдчилгаа	4,450.0	134,895.7	130,445.7
Бараа материал	616,888.6	201,630.8	(415,257.8)
Бусад эргэлтийн хөрөнгө	5,595,179.3	5,575,979.3	(19,200.0)
Үндсэн хөрөнгө	2,363,630.6	2,320,009.0	(43,621.6)
Нийт хөрөнгө	8,730,496.5	8,233,079.2	(497,417.3)
Өр төлбөр	181.0	92,282.1	92,101.1
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,730,315.5	8,140,797.1	(589,518.4)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	8,730,496.5	8,233,079.2	(497,417.3)

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо дансдууд байна. Тухайлбал,

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 150,000.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд байгуулсан ахмадын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг тайлант онд зарцуулсантай холбоотой байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 130,445.7 мянган төгрөгөөр өссөн нь нэг жилийн хугацаатай лиценз, үйлчилгээний төлбөрийн тайлант онд ногдохгүй зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 415,257.8 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор нийт 263,835.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 222,352.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, ТНБД-ын 2025 оны А/178, А/301 дүгээр тушаалаар 428,058.6 мянган төгрөгийн бараа материал акталж, эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр 28,682.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 43,621.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд нэмэгдсэн 832,213.7 мянган төгрөгийн хөрөнгө, хасагдсан 809,395.2 мянган төгрөгийн хөрөнгө болон 66,440.1 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн зөрүү байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 451,553.8 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж, ТӨБЗГ-ын 2025 оны 475, 878 дугаар тогтоолоор 273,885.5 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, ТӨБЗГ-ын 2025 оны 731 дүгээр тогтоолоор 106,774.4 мянган төгрөгөөр хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож, ТӨБЗГ-ын 2025 оны 358, 778 дугаар тогтоолоор 619,128.8 сая төгрөгийн хөрөнгө акталж, ТӨБЗГ-ын 2025 оны 749 дүгээр тогтоолоор 190,266.4 мянган төгрөгийн хөрөнгийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв ТӨААТҮГ болон Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэнд балансаас балансанд шилжүүлсэн байна.

Байгууллагын биет бус хөрөнгөд 18,689.0 мянган төгрөгийн яамны вебсайт, 65,837.0 мянган төгрөгийн программ хангамж, 49,657.5 мянган төгрөгийн лиценз бүртгэлтэй байна. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу нэг жилээс доош хугацаанд ашиглагдах лицензийн төлбөрийг биет бус хөрөнгөд бүртгэхгүйгээр, тайлант онд ногдох зардлыг санхүүгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрч, ногдохгүй зардлыг урьдчилж гарсан зардлаар бүртгэж байна.

Өглөг дансны үлдэгдэл 92,101.1 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн төсөлд батлагдаагүй ажил үйлчилгээ үзүүлэх гэрээг 4 хуулийн этгээд, 2 хувь хүнтэй байгуулж, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг төлөөгүйгээс голлон шалтгаалсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 589,518.4 мянган төгрөгөөр буурсан нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт 24,878.4 мянган төгрөгөөр өссөн, тайлант оны үр дүн 614,396.8 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус яамны 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 40,769,941.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 01/1397 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн байна.

Төсвийн төсөлд төсөвлөсөн дүнгээс материаллаг өөрчлөлт гарсан зардлын үзүүлэлтийг дурдвал цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 140,204.6 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл зардлыг 25,116.3 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 13,459.0 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 10,330,308.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, хангамж, бараа материалын зардлыг 249,294.3 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 1,064,075.8 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 1,241,812.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамжийн зардлыг 32,986,527.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 170,631.0 мянган төгрөг, засгийн газрын урсгал шилжүүлгийг 21,978.6 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 315,131.4 мянган төгрөгөөр тус тусбууруулж 2025 оны төсвийг 23,364,005.3 мянган төгрөгөөр баталсан нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

Төсвийн захирагчийн 2025 оны төсвийн нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 23,364,005.3 мянган төгрөгөөр тооцон баталсан бөгөөд тайлант оны батлагдсан төсвийг 6,313,365.4 мянган төгрөгөөр бууруулж 17,050,639.9 мянган төгрөг болгон тодотгосон байна. Үүнд:

Цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардлыг 305,963.9 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 23,390.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 2,651,331.3 мянган төгрөг, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас зардлыг 5,581,910.5 мянган төгрөг, урсгал шилжүүлгийн зардлыг 197,807.2 мянган төгрөгөөр бууруулж, хангамж, бараа материалын зардлыг 68,064.9 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 344,788.8 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 1,956,824.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 77,360.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 17,050,639.9 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 12,011,452.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, 11,923,321.8 мянган төгрөгийг зарцуулж, 88,131.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 11,923,321.8 мянган төгрөг буюу 68.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 180,109.0 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 57,149.7 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 73,565.5 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардлыг 177,068.0 мянган төгрөг, томилолт, зочны зардлыг 1,409,157.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 684,844.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад

зардлыг 37,305.1 мянган төгрөг, хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас зардлыг 2,520,416.1 мянган төгрөг, засгийн газрын урсгал шилжүүлгийн зардлыг 98,566.3 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийг 5,702.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2.Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Код	Нэр				
70202	Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт	17,050,639.9	11,923,321.8	5,127,318.1	68.3
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	10,821,042.0	8,699,064.6	2,121,977.4	77.6
80205	Мэдээлэл, сурталчилгааны зардал	107,554.4	44,995.0	62,559.4	41.8
80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	214,310.0	104,460.0	109,850.0	48.7
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	509,278.2	501,452.7	7,825.4	95.1
80239	Тээврийн үйлчилгээ	50,000.0	33,013.4	16,986.6	66.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	72,681.0	66,978.6	5,702.4	92.2
81569	Төрийн зарим үйлчилгээг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	527,376.5	245,375.7	282,000.8	46.5
80404	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	4,748,397.8	2,227,981.8	2,520,416.0	46.9

Монгол Улсын хөгжлийн 2026 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэлийн "Төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор багш, эмч нараас бусад төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлнэ" гэж заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн А/177 дугаар тушаалаар яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн орон тоог 151 болгон 9 газар 19 хэлтсийг 9 газар 9 хэлтэс болгож, удирдах 10, гүйцэтгэх 5 албан тушаалтныг цомхотгон ажилласан байна.

Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД-ын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар яамны албан хаагчдын хоолны зардлыг ажлын нэг өдөрт 30.0 мянган төгрөг, унааны зардлыг 5.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

Тайлант онд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахад 30,000.0 мянган төгрөг, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомжийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулахад 10,000.0 мянган төгрөгийг Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, санхүүжүүлсэн байна.

Эдийн засаг, хөгжлийн яамны Гадаад албан томилолтын зардалд нийт 1,313,321.1 мянган төгрөг төлөвлөгдсөнөөс 759,650.6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Тайлант онд ТНБД-ын тушаалаар 27 гадаад албан томилолтын арга хэмжээг төлөвлөж, 25 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна.

Хэрэгжсэн гадаад томилолтын арга хэмжээнээс 3 арга хэмжээ нь дээд шатны байгууллагын шийдвэртэй бол 22 арга хэмжээ нь Эдийн засаг, хөгжлийн яамны чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой байна. Гадаад албан томилолтын төсөвлөлт, зарцуулалттай холбоотой зөрчлийг тус тайлангийн 5 дугаар бүлэгт тусгасан болно.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хаана, хэрхэн байгууллагын нэр дурдагдаж байгааг олж илрүүлэх, өгөгдөл цуглуулах, хандлагыг бодит цаг хугацаанд хянах боломжийг олгодог үйлчилгээний эрх 18,900.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Эдийн засаг, хөгжлийн яамны нэмэлт санхүүжилтийн дансанд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн “Хөрөнгө гаргах тухай” 06 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас 911,145.8 мянган төгрөг, яамны цайны газрын түрээсийн орлого 6,380.0 мянган төгрөг, нийт 917,525.8 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр Шинжлэх ухааны академийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн гадна тохижилт, ажил, амралтын байрны засварын ажил, судалгааны зориулалттай дуран, тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж худалдан авахад нийт 911,145.8 мянган төгрөгийг зарцуулж, түрээсийн орлогын 6,380.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтийн эх үүсвэрээр бэлтгэсэн хөрөнгийг бусад эргэлтийн хөрөнгөд бүртгэж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн А-1/1755 дугаар албан бичиг, 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Одон орон, геофизикийн хүрээлэн рүү шилжүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/21, нэмэлт А/49 дүгээр тушаалаар тус яамны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 498,370.0 мянган төгрөг, харьцуулалтын аргаар 452,000.0 мянган төгрөг, ерөнхий гэрээний журмаар 180,000.0 мянган төгрөг, нэг эх үүсвэрээс 195,045.8 мянган төгрөг, шууд худалдан авалтын аргаар 407,709.0 мянган төгрөг нийт 1,733,124.8 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 1,279,843.4 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдаж авснаас нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 460,947.4 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, лиценз, харьцуулалтын аргаар 262,298.0 мянган төгрөгийн зөвлөх үйлчилгээ, тоног төхөөрөмж, лиценз, нэг эх үүсвэрээс 198,437.4 мянган төгрөгийн лиценз, шууд худалдан авалтаар 358,160.6 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авч бэлтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн яамны үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт, үндсэн хөрөнгө, бараа материал, урсгал зардал, гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, худалдан авах ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын аудитор Г.Тэлмүүн, ахлах аудитор Д.Мөнхжин нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар хэрэгжүүлсэн.

Эдийн засаг, хөгжлийн яам 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 03/157 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 15,638,249.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 156,382.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 13,855,982.7 мянган төгрөг болж, 2024 оноос 11.4 хувиар буурсан нь нөлөө бүхий өөрчлөлт гэж үзлээ.

Материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 13,855,982.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 138,559.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.


4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 252,032.8 мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 3 албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 1,762,897.8 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.



4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын 1,762,897.8 мянган төгрөгийн 76 гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд байршуулж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтын харьцуулалтын аргаар үнийн санал дуудаж зохион байгуулахдаа хүчингүй болсон тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийг ашигласан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Тендер шалгаруулалтын баримт бичгийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан жишиг баримт бичиг, маягт, гэрээний нөхцөл болон холбогдох журам, аргачлалын дагуу боловсруулж, захиалагч батална.". Сангийн сайдын 2025 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А/106 дугаар тушаалын нэгдүгээр хавсралттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хүчин төгөлдөр тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийг ашиглаж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитад яамны 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, урсгал зардал, нэмэлт санхүүжилтийн данснуудын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Завсрын аудитаар илрүүлсэн 2,361,851.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил бүхий асуудлын бүртгэлийг боловсруулж, 3 төлбөрийн акт, 5 албан шаардлага, 1 зөвлөмжийг жилийн эцсийн аудитад нэгтгэсэн болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн төлбөр барагдуулах 170,980.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, зөрчлийг таслан зогсоох 56,342.5 мянган төгрөгийн 1 албан шаардлагын биелэлт 100.0 хувьтай, алдааг засах 945,087.1 мянган төгрөгийн 15 зөвлөмжийн биелэлт 74.2 хувьтай, нийт шийдвэрийн хэрэгжилт 79.2 хувьтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	170,980.0	1	170,980.0	100.0
Албан шаардлага	1	56,342.5	1	56,342.5	100.0
Зөвлөмж	15	945,087.1	11	701,680.7	74.2
Нийт дүн	17	1,172,409.6	13	929,003.2	79.2

Өмнөх аудитаар өгсөн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалтыг үйл ажиллагаандаа баримталж ажиллах, албан томилолтын зардлын тушаал гаргахдаа Сангийн сайдын 2011 оны 188 дугаар тушаалд тусгагдаагүй зардлыг төсөвлөхгүй байх, иж бүрэн анхан шатны баримтаар ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд тусгаж ажиллах болон Шилэн дансны цахим сайтад байршуулах мэдээллийг хуульд заасан хугацаанд иж бүрэн байршуулж ажиллах 4 зөвлөмж өгсөн боловч тайлант онд хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, зөрчил давтагдан гарсан тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд:

- Засгийн газрын 11 дүгээр байранд хийсэн их засварын ажлын чанарын баталгааг дараа онд чөлөөлж байгаатай холбоотойгоор бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй 5,575,979.3 мянган төгрөгийн хөрөнгийг Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газарт балансаас балансанд шилжүүлж, барилгын өртөгт шингээн капиталжуулсан эсэх;
- Байгууллагын ашигладаг санхүүгийн программ нь Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бүрэн шинэчлэл хийгдсэн эсэх;
- Сангийн сайдын 2025 оны 112 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал", "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбар", "Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал"-ыг төсвийн гүйцэтгэл, тайлагналдаа хэрэгжүүлж ажилласан эсэх;
- МУ-ын Засгийн газрын 2024 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 23 дугаар тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яамны харьяанд "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" ТӨААТҮГ-ыг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх зорилгоор 2024 онд шаардагдах эх үүсвэрийг батлагдсан төсвийн багцдаа багтаан зохицуулалт хийх замаар, цаашид үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэж ажиллахыг МУТШСБЭЗХС-д даалгасан байна. "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн төв" ТӨААТҮГ-ын 2025 оны урсгал зардлын төсөв зарцуулах эрхийг тус газрын захиралд шилжүүлж, нийт 2,227,981.7 мянган төгрөгийн санхүүжилтийн гүйцэтгэлийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар үзэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 919,594.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 919,594.8 мянган төгрөгийн алдааг бүрэн залрууллаа.

Залруулсан алдаа:

- ТӨБЗГ-ын 2026 оны 31 дүгээр тогтоолын дагуу 911,145.8 мянган төгрөг, бусад 2,069.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэхдээ санхүүгийн үр дүнгийн тайланд бараа материал шилжүүлсний зардал (210409) буюу үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрсөн;
- Эдийн засаг, хөгжлийн яамны цайны газрын түрээсийн орлого 6,380.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн үр дүнгийн тайлан, нэмэлт төсвийн тайлангаас цэвэрлэж тайлагнасан.

Залруулсан алдаа: УСНББОУС-1-ийн 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга ажил гүйлгээ, бусад үйл явдал ба нөхцөл байдлуудыг үзэл баримтлалд заасан хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тодорхойлолт болон хүлээн зөвшөөрөлтийн шалгуурт нийцүүлэн үнэн зөв илэрхийлэхийг шаарддаг", санхүүгийн тайлангийн толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй тул алдааг аудитын явцад бүрэн залрууллаа.

Аудитаар нийт 813,328.3 мянган төгрөгийн зөрчил²илэрснээс, 2,649.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 754,632.2 мянган төгрөгийн 9 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 56,047.1 мянган төгрөгийн 4 зөрчилд зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй 813,328.3 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 674,768.5 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Яамны урсгал төсвөөс 6,499.0 мянган төгрөгийн Starlink хөдөлгөөнт интернэт төхөөрөмж худалдан авсан байна. Аудитаар тус төхөөрөмжийг 3,850.0 мянган төгрөгийн үнэтэй болохыг тогтоосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.4-д "үнэн зөв байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зах зээлийн үнээс өндөр үнээр хөдөлгөөнт интернэт төхөөрөмж худалдан авсан зөрчилд 2,649.0 мянган төгрөгийн зөрүү төлбөрийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

1. Гадаад албан томилолттой холбоотой

Илрүүлэлт 1: Эдийн засаг, хөгжлийн яамны удирдах албан тушаалтнууд гадаад албан томилолтоор энгийн зэрэглэлээс бусад суудлаар зорчиж, нэмэлт зардлыг нийт томилолтын багийн тийзийн үнэд шингээх замаар төсөвлөн санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд агаарын тээврийн хэрэгслээр албан томилолтоор энгийн зэрэглэлээс бусад суудлаар төсвийн болон байгууллагын хөрөнгөөр зорчихыг хориглоно. 3.1. Энэ хуулийн үйлчлэлд дараах хуулийн этгээд, албан тушаалтан, санхүүжилтийн эх үүсвэр хамаарна", 3 дугаар зүйлийн 3.1.1-д "төрийн улс төрийн, захиргааны, тусгай болон үйлчилгээний албан хаагч", 3.1.2-т "төсвийн байгууллага, түүний албан тушаалтан" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад албан томилолтоор энгийн зэрэглэлээс бусад суудлаар зорчсон нэмэлт зардлын зөрүүг томилолтын багийн гишүүдийн нийт тийзийн үнэд шингээх замаар төсөвлөж байгаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Илрүүлэлт 2: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, Сангийн сайдын 2011 оны "Гадаад албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" 188 дугаар тушаалаар баталсан зардалд тусгагдаагүй уулзалтын танхимын түрээсийн төлбөр болон тогтоосон нормативаас илүү хэмжээгээр зам хоног, зочид буудлын зардлыг төсөвлөж, нийт 70,153.5 мянган төгрөг хэтрүүлэн олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.9-д "улсаас хатуу тогтоосноос бусад бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох", 20.1.10-д "эрх хэмжээнийхээ асуудлаар хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг биелүүлэхийн тулд тэдгээрт нийцүүлэн тухайн үйлдвэрийн газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах", Сангийн сайдын 2011 оны "Гадаад томилолтын зардлын хэмжээг батлах тухай" 188 дугаар тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гадаад албан томилолтын зардлын тушаал гаргахдаа албан ажлаар ажиллах хугацааны зам хоног, буудлын зардлаас бусад зардлыг санхүүжүүлдэг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Илрүүлэлт 3: Яамны гадаад томилолтын зардлаас байгууллагын үндсэн ажилтнаас бусад албан тушаалтны гадаад албан томилолтын зардалд зам хоног, зочид буудлын 9,318.1 мянган төгрөг, нислэгийн 5,025.3 мянган төгрөгийн зардал санхүүжүүлж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын үндсэн ажилтнаас бусад албан тушаалтны гадаад албан томилолтын зардлыг яамны төсвөөс санхүүжүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт 1: Төсөвт батлагдаагүй, төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон, дараах зардлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Өдрийн сонинд мэндчилгээ нийтлүүлэхэд 1,500.0 мянган төгрөг;

- Яамны үйл ажиллагааг сурталчлах болон Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын баярын мэндчилгээний контент бэлтгэхэд 31,200.0 мянган төгрөг;
- Амралт сувилалын газарт сургалт зохион байгуулахтай холбоотой хоолны зардалд 9,279.6 мянган төгрөг, автобус түрээсийн зардалд 1,400.0 мянган төгрөг;
- ЭЗХЯ-ны стратеги төлөвлөгөө хэвлүүлэхэд 1,500.0 мянган төгрөг;
- PVC хэвлэлд 2,497.0 мянган төгрөг;
- Авто машин угаалгахад 1,400.0 мянган төгрөг;
- Үндэсний их баяр наадмын билет худалдан авахад 1,280.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т "Энэ хуулийн 4.1-д заасан зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 4.2.2-т "хэмнэлтийн горим нь иргэд, олон нийтийн ашиг сонирхолд нийцэж, тэдний дэмжлэгийг хүлээхүйц түвшинд тодорхойлогдсон байх", 15 дугаар зүйлийн 15.1.4-т "Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх", 15.2-т Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд дараах арга хэмжээг авч ажиллана: "15.2.7.сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг амралт, сувилал, жуулчны баазад зохион байгуулахгүй байх, шаардлагатай бол хот суурин газарт зориулалтын хурлын танхимд, эсхүл цахимаар зохион байгуулах зэргээр түрээс, шатахуун, албан томилолтын зардлыг хэмнэх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт төлөвлөөгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлыг санхүүжүүлдэг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Илрүүлэлт 2: Төрийн хэмнэлтийн тухай хуулиар автомашин ашиглахыг хориглосон Төрийн нарийн бичгийн дарга, Монгол улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын ажлын албаны зөвлөх нар албан тушаалын автомашин ашиглаж, дараах нэмэлт зардлууд гаргасан байна. Үүнд:

- Жолоочийн цалингийн зардалд 15,754.6 мянган төгрөг;
- Автомашины засвар, үйлчилгээнд 1,281.7 мянган төгрөг;
- Сэлбэг хэрэгсэлд 4,950.0 мянган төгрөг;
- Шатахууны зардалд 12,939.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулиар автомашин ашиглахыг хориглосон албан тушаалтан автомашин ашиглаж, нэмэлт зардал гаргаж байгаа зөрчлийг таслан зогсоож, тус автомашинуудыг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт шилжүүлэх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

3. Урсгал зардалтай холбоотой

Илрүүлэлт 1: Төсөвт батлагдаагүй, байгууллагын үндсэн чиг үүрэгтэй хамааралгүй нийт 49,530.0 мянган төгрөгийн үр ашиггүй зарцуулалт гаргасан байна. Үүнд:

- Яамны үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй 3 ширхэг ном худалдан авахад 2,850.0 мянган төгрөг;
- Яамны үндсэн хөрөнгөд бүртгэлгүй "Мерседес бенз" загварын автомашины мастер түлхүүрийг нөхөн олшруулах төлбөрт 880.0 мянган төгрөг;
- "Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл" боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ хувь хүнтэй байгуулан 12,000.0 мянган төгрөг, хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахдаа дотоод нөөцийг ашиглалгүй Хөгжлийн эрх зүйн төв НҮТББ-аар зохион байгуулуулж 18,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.
- Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойн хүрээнд хийгдсэн "Төрийн албаны реформ-Бидний шийдэл" төрийн албан хаагчдын судалгаа, эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн эмхэтгэлийг 15,800.00 мянган төгрөгөөр 1000 ширхэг хэвлүүлж, холбогдох тушаал шийдвэргүй Төрийн албаны зөвлөлд үнэ төлбөргүй шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлээгүй, яамны үндсэн чиг үүрэгт хамааралгүй зарцуулалт гаргадаг зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Илрүүлэлт 2: Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд Бөгөөд Эдийн Засаг Хөгжлийн Сайд нь байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлгүй, Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийн нэгж дээр бүртгэлтэй 0157 УКР Ланд круйзер 300 загварын автомашиныг ашиглаж, шатахууны зардалд 1,979.2 мянган төгрөгийг яамнаас санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн "Төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрх: 1-т / өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Яамны үндсэн хөрөнгөд бүртгэлгүй автомашин ашиглаж, зардал гаргасан зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Илрүүлэлт 3: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, Эдийн засаг, хөгжлийн яамны ТНБД-ын тушаалаар гадны зочин төлөөлөгч хүлээн авах зардлын төсөв батлаж, 15 хуулийн этгээдтэй хоол болон танхимын түрээсийн үйлчилгээний гэрээ байгуулсан боловч анхан шатны баримтаар нотлогдохгүй, гэрээ байгуулснаас өөр хуулийн этгээдийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг болон тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлэн нийт 280,544.6 мянган төгрөгийн залилангийн шинжтэй гүйлгээг санхүүжүүлсэн байна. Үүнд:

- Кей Би Эм Стар Гоалд ХХК болон Цагчиг гоалд ХХК-тай гэрээ байгуулан үйл ажиллагаагаа 2024 онд зогсоосон "Rock salt" болон "ANAR Restaurant & Lounge" зоогийн газруудаар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж нийт 47,350.2 мянган төгрөг;

- Мөнх өрнөх хүч ХХК-тай гэрээ байгуулан Интер стандарт брьюри ХХК-ийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг "Brussels belgian beer safe" зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж 9,600.0 мянган төгрөг;
- Сантино стар гоалд ХХК-тай гэрээ байгуулан Истерн нүүдэл ХХК-ийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг "The Green zone" зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж 17,404.0 мянган төгрөг;
- Тэгш аман шанд ХХК-тай гэрээ байгуулан Махамаяа ХХК-ийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг "Mexikhan" зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж 15,000.0 мянган төгрөг;
- Би Эй Ар Эн Өү Даблью Эл ХХК-тай гэрээ байгуулан Мишээл ирмүүн ХХК-ийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг "MICHELLE DINING RESTAURANT" зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж 11,027.5 мянган төгрөг;
- МНА энх чингис ХХК-тай гэрээ байгуулан Ти Оу Эм ХХК-ийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг "Terrazza" зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж 19,050.0 мянган төгрөг;
- Кэй Си Жи лэнд фүүдс ХХК-тай 3 удаагийн, Сүлдара спарк ВМКМ ХХК-тай 2 удаагийн гэрээ байгуулан Рөүт катеринг ХХК-ийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг "Route 22 Restaurant & Wine Lounge" зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж нийт 43,056.0 мянган төгрөг;
- Эйч Би Эм сүүн трейд ХХК-тай гэрээ байгуулан Рөүт катеринг ХХК-ийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг "ZOMA Kitchen & Bar" зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж 25,612.5 мянган төгрөг;
- Бум дэвжих ХХК-тай 21,311.9 мянган төгрөг, Буудай үржин арвижих ХХК-тай 11,142.5 мянган төгрөг, Ди Эс Эф Партнерс ХХК-тай 11,310.0 мянган төгрөг, Тэгш аман шанд ХХК-тай 7,700.0 мянган төгрөг, Хулан лидершип ХХК-тай 10,350.0 мянган төгрөг, Шимт ээдэ тур ХХК-тай 30,630.0 мянган төгрөгийн анхан шатны баримтаар нотлогдохгүй, залилангийн шинжтэй гүйлгээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Төсөв нь Улсын болон Аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх бөгөөд төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.3.2 "санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах", 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтаар нотлогдохгүй, гэрээ байгуулснаас өөр хуулийн этгээдийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг болон тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Төсөвт батлагдаагүй ажил үйлчилгээ үзүүлэх нийт 173,122.2 мянган төгрөгийн гэрээг 4 хуулийн этгээд, 2 хувь хүнтэй байгуулснаас тайлант оны эцэст 89,422.2 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг

хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөвт батлагдаагүй ажил үйлчилгээг үзүүлэх гэрээ байгуулж, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой

Илрүүлэлт 1: Эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр 13,497.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэхдээ эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрт үндэслэж байх.

Илрүүлэлт 2: Байгууллагын шатахууны зарцуулалтад тавигдах хяналт сул, шатахууныг бараа материалын орлогоор бүртгэж, зарлагдахдаа жолооч дээр тооцоо үүсгэлгүй шууд зардлаар хүлээн зөвшөөрч байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууныг бараа материалаас зарлагдахдаа жолооч дээр тооцоо үүсгэж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах.

2. Урсгал зардалтай холбоотой

Илрүүлэлт 1: Microsoft office 365 лицензийн 200 ширхэг эрх худалдан авах ажиллагааг зохион байгуулах хугацаанд байгууллагын батлагдсан орон тоо 154, дунджаар 115 хүний орон тоотой ажиллаж байсан буюу хэрэгцээ шаардлагаас илүү тоогоор худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хэрэгцээ шаардлагаас илүү тоогоор лицензийн эрх худалдан авахгүй байх.

Илрүүлэлт 2: Төсвийн төсөлд батлагдаагүй, "Жи Эс Ди Би Эл" ХХК-тай гэрээ байгуулан "BrandMentions" мониторинг, өгөгдөл цуглуулах үйлчилгээний эрх буюу онлайн орчинд хаана, хэрхэн байгууллагын нэр дурдагдаж байгааг олж илрүүлэх, өгөгдөл цуглуулах, хандлагыг бодит цаг хугацаанд хянах боломжийг олгодог үйлчилгээний эрх худалдан авахад 18,900.0 мянган төгрөг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын чиг үүрэгт хамааралгүй, төсөвт батлагдаагүй хэвлэл мэдээллийн зардал гаргахгүй байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
ТӨБЗГ-ын 2026 оны 31 дүгээр тогтоолын дагуу 911,145.8 мянган төгрөг, бусад 2,069.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэхдээ Үр дүнгийн тайланд Бараа материал шилжүүлсний зардал (210409) буюу үйл ажиллагааны зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.	1	913,214.8	-	-	1	913,214.8	1	913,214.8	-	-	-	-
ЭЗХЯ-ны цайны газрын түрээсийн орлого болох 6,380.0 мянган төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайлан, Үр дүнгийн тайлан, Нэмэлт санхүүжилтийн тайлангаас цэвэрлэж тайлагнасан байна.	1	6,380.0	1	6,380.0	-	-	1	6,380.0	-	-	-	-
Дүн	2	919,594.8	1	6,380.0	1	913,214.8	2	919,594.8	-	-	-	-

Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						/мянган төгрөгөөр/ Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Байгууллагын урсгал төсвөөс 6,499.0 мянган төгрөгийн Starlink хөдөлгөөнт интернет төхөөрөмж худалдан авсан байна. Аудитаар тус төхөөрөмжийг 3,850.0 мянган төгрөгийн үнэтэй болохыг тогтоосон.	1	2,649.0	1	2,649.0	-	-	-	-	-	-
Төсөвт батлагдаагүй, байгууллагын үндсэн чиг үүрэгтэй хамааралгүй нийт 49,530.0 мянган төгрөгийн үр ашиггүй зарцуулалт гаргасан байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Яамны үндсэн үйл ажиллагаанд хамааралгүй 3 ширхэг ном худалдан авахад 2,850.0 мянган төгрөг; • Яамны үндсэн хөрөнгөд бүртгэлгүй "Мерседес бенз" загварын автомашины мастер түлхүүрийг нөхөн олшруулах төлбөрт 880.0 мянган төгрөг; • "Уур амьсгалын өөрчлөлтийн тухай хуулийн төсөл" боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээ хувь хүнтэй байгуулан 12,000.0 мянган төгрөг, хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахдаа дотоод нөөцийг ашиглалгүй Хөгжлийн эрх зүйн төв НҮТББ-аар зохион байгуулуулж 18,000.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан. • Төрийн албаны зөвлөлийн 30 жилийн ойн хүрээнд хийгдсэн "Төрийн албаны реформ-Бидний шийдэл" төрийн албан хаагчдын судалгаа, эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийн эмхэтгэлийг 15,800.00 мянган төгрөгөөр 1000 ширхэг хэвлүүлж, холбогдох тушаал шийдвэргүй Төрийн албаны зөвлөлд үнэ төлбөргүй шилжүүлсэн байна. 	1	49,530.0	-	-	1	49,530.0	-	-	-	-
Монгол Улсын Тэргүүн Шадар Сайд Бөгөөд Эдийн Засаг Хөгжлийн Сайд нь байгууллагын үндсэн хөрөнгөд	1	1,979.2	-	-	1	1,979.2	-	-	-	-

Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<p>бүртгэлгүй, Аймаг, сумын бүсчилсэн, ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийн нэгж дээр бүртгэлтэй 0157 УКР Ланд круйзер 300 загварын автомашиныг ашиглаж, шатахууны зардалд 1,979.2 мянган төгрөгийг яамнаас санхүүжүүлсэн байна.</p>										
<p>Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, Сангийн сайдын 2011 оны "Гадаад албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" 188 дугаар тушаалаар баталсан зардалд тусгагдаагүй уулзалтын танхимын түрээсийн төлбөр болон тогтоосон нормативаас илүү хэмжээгээр зам хоног, зочид буудлын зардлыг төсөвлөж, нийт 70,153.5 мянган төгрөг хэтрүүлэн олгосон байна.</p>	1	70,153.5	-	-	1	70,153.5	-	-	-	-
<p>Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, ЭЗХЯ-ны ТНБД-ын тушаалаар гадны зочин төлөөлөлөгч хүлээн авах зардлын төсөв батлаж, 15 хуулийн этгээдтэйхоол болон танхимын түрээсийн үйлчилгээний гэрээ байгуулан анхан шатны баримтаар нотлогдохгүй, гэрээ байгуулснаас өөр хуулийн этгээдийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг болон тайлант онд үйл ажиллагаа явуулаагүй зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлэн нийт 280,544.6 мянган төгрөгийн залилангийн шинжтэй гүйлгээг санхүүжүүлсэн байна. Үүнд: - Мөнх өрнөх хүч ХХК болон Цагчиг гоалд ХХК-тай гэрээ байгуулан үйл ажиллагаагаа 2024 онд зогсоосон "Rock salt" болон "ANAR Restaurant & Lounge" зоогийн газруудаар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж нийт 47,350.2 мянган төгрөг; - Мөнх өрнөх хүч ХХК-тай гэрээ байгуулан Интер стандарт брьюри ХХК-ийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг "Brussels belgian beer cafe" зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж 9,600.0 мянган төгрөг; - Сантино стар гоалд ХХК-тай гэрээ байгуулан Истерн нүүдэл ХХК-ийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг "The Green zone" зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж 17,404.0 мянган төгрөг; - Тэгш аман шанд ХХК-тай гэрээ байгуулан Махамаяа ХХК-ийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг "Mexikhan" зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж 15,000.0 мянган төгрөг; - Би Эй Ар Эн Өү Даблю Эл ХХК-тай гэрээ байгуулан</p>	1	280,544.6	-	-	1	280,544.6	-	-	1	280,544.6


Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<p>Мишээл ирмүүн ХХК-ийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг "MICHELLE DINING RESTAURANT" зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж 11,027.5 мянган төгрөг;</p> <p>- МНА энх чингис ХХК-тай гэрээ байгуулан Ти Оу Эм ХХК-ийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг "Terrazza" зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж 19,050.0 мянган төгрөг;</p> <p>- Кэй Си Жи лэнд фүүдс ХХК-тай 3 удаагийн, Сүлдара спарк ВМКМ ХХК-тай 2 удаагийн гэрээ байгуулан Рөүт катеринг ХХК-ийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг "Route 22 Restaurant & Wine Lounge" зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж нийт 43,056.0 мянган төгрөг;</p> <p>- Эйч Би Эм сүүн трейд ХХК-тай гэрээ байгуулан Рөүт катеринг ХХК-ийн эзэмшилд үйл ажиллагаа явуулдаг "ZOMA Kitchen & Bar" зоогийн газраар үйлчлүүлсэн баримт бүрдүүлж 25,612.5 мянган төгрөг;</p> <p>- Бум дэвжих ХХК-тай 21,311.9 мянган төгрөг, Буудай үржин арвижих ХХК-тай 11,142.5 мянган төгрөг, Ди Эс Эф Партнерс ХХК-тай 11,310.0 мянган төгрөг, Тэгш аман шанд ХХК-тай 7,700.0 мянган төгрөг, Хулан лидершип ХХК-тай 10,350.0 мянган төгрөг, Шимт ээдэ тур ХХК-тай 30,630.0 мянган төгрөгийн анхан шатны баримтаар нотлогдохгүй, залилангийн шинжтэй гүйлгээг тус тус санхүүжүүлсэн байна.</p>										
<p>Төрийн хэмнэлтийн тухай хуулиар автомашин ашиглахыг хориглосон Төрийн нарийн бичгийн дарга, Монгол улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын ажлын албаны зөвлөх нар албан тушаалын автомашин ашиглаж, дараах нэмэлт зардлууд гаргасан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Жолоочийн цалингийн зардалд 15,754.6 мянган төгрөг; - Автомашины засвар, үйлчилгээнд 1,281.7 мянган төгрөг; - Сэлбэг хэрэгсэлд 4,950.0 мянган төгрөг; - Шатахууны зардалд 12,939.5 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. 	1	34,925.8	-	-	1	34,925.8	-	-	-	-
<p>Төсөвт батлагдаагүй, төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон, дараах зардлуудыг санхүүжүүлсэн байна. Үүнд:</p>	1	50,056.6	-	-	1	50,056.6	-	-	-	-

Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<ul style="list-style-type: none"> - Өдрийн сонинд мэндчилгээ нийтлүүлэхэд 1,500.0 мянган төгрөг; - Яамны үйл ажиллагааг сурталчлах болон Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайдын баярын мэндчилгээний контент бэлтгэхэд 31,200.0 мянган төгрөг; - Амралт сувилалын газарт сургалт зохион байгуулахтай холбоотой хоолны зардалд 9,279.6 мянган төгрөг, автобус түрээсийн зардалд 1,400.0 мянган төгрөг; - ЭЗХЯ-ны стратеги төлөвлөгөө хэвлүүлэхэд 1,500.0 мянган төгрөг; - PVC хэвлэлд 2,497.0 мянган төгрөг; - Авто машин угаалгахад 1,400.0 мянган төгрөг; - Үндэсний их баяр наадмын билет худалдан авахад 1,280.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. 										
Төсөвт батлагдаагүй ажил үйлчилгээ үзүүлэх нийт 173,122.2 мянган төгрөгийн гэрээг 4 хуулийн этгээд, 2 хувь хүнтэй байгуулснаас тайлант оны эцэст 89,422.2 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.	1	89,422.2	-	-	1	89,422.2	-	-	-	-
Яамны гадаад томилолтын зардлаас байгууллагын үндсэн ажилтнаас бусад албан тушаалтны гадаад албан томилолтын зардалд зам хоног, зочид буудлын 9,318.1 мянган төгрөг, нислэгийн 5,025.3 мянган төгрөгийн зардал санхүүжүүлж, төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.	1	14,343.4	-	-	1	14,343.4	-	-	-	-
Эдийн засаг, хөгжлийн яамны удирдах албан тушаалтнууд гадаад албан томилолтоор энгийн зэрэглэлээс бусад суудлаар зорчиж, нэмэлт зардлыг нийт томилолтын багийн тийзийн үнэд шингээх замаар төсөвлөн санхүүжүүлсэн байна.	1	163,676.9	-	-	1	163,676.9	-	-	-	-
Microsoft office 365 лицензийн 200 ширхэг эрх худалдан авах ажиллагааг зохион байгуулах хугацаанд байгууллагын батлагдсан орон тоо 154, дунджаар 115 хүний орон тоотой ажиллаж байсан буюу хэрэгцээ шаардлагаас илүү тоогоор худалдан авалт хийсэн байна.	1	23,650.0	-	-	-	-	1	23,650.0	-	-
Байгууллагын шатахууны зарцуулалтад тавигдах хяналт сул, шатахууныг бараа материалын орлогоор бүртгэж, зарлагдахдаа тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар хүлээн зөвшөөрч байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-
Төсвийн төсөлд батлагдаагүй, "Жи Эс Ди Би Эл" ХХК-тай гэрээ байгуулан "BrandMentions" мониторинг, өгөгдөл	1	18,900.0	-	-	-	-	1	18,900.0	-	-

САГ-2026/350/НА-СТА ТШЗ



Эдийн засаг, хөгжлийн яамны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

цуглуулах үйлчилгээний эрх буюу онлайн орчинд хаана, хэрхэн байгууллагын нэр дурдагдаж байгааг олж илрүүлэх, өгөгдөл цуглуулах, хандлагыг бодит цаг хугацаанд хянах боломжийг олгодог үйлчилгээний эрх худалдан авахад 18,900.0 мянган төгрөг зарцуулж, үр ашиггүй зардал гаргасан байна.										
Эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр 13,497.1 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэн байна.	1	13,497.1	-	-	-	-	1	13,497.1	-	-
Нийт дүн	14	813,328.3	1	2,649.0	9	754,632.2	4	56,047.1	1	280,544.6

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын 1,762,897.8 мянган төгрөгийн 76 гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна.	1	1,762,897.8	1	1,762,897.8	-	-
Дүн	1	1,762,897.8	1	1,762,897.8	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Худалдан авах ажиллагааг тендер шалгаруулалтын харьцуулалтын аргаар үнийн санал дуудаж зохион байгуулахдаа хүчингүй болсон тендер шалгаруулалтын жишиг баримт бичгийг ашигласан байна.	1	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	1	-
Нийт дүн	2	1,762,897.8	1	1,762,897.8	1	-